



"ХОТ ДЕВЕЛОПМЕНТ" ХК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2018

УЛААНБААТАР ХОТ

I. Ерөнхий мэдээлэл

Байгуулагдсан огноо:	1999.01.18
Үйл ажиллагааны чиглэл:	Бизнесийн зөвлөгөө өгөх Гадаад худалдаа
Улсын бүртгэлийн дугаар:	9010387001
Регистрын дугаар:	2116812
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	45 хувьцаа эзэмшигчид 39,885 хувьцаа эзэмшиж байна /2018.04.08-ны өдрийн бүртгэлийн өдрөөрх тархалтын судалгаа/
Хаяг	Хан-Уул дүүрэг, Махатма Гандигийн гудамж, Галакси Тауэр, 902 тоот
Утас:	75753302, 99042846

II. Компанийн бизнесийн үйл ажиллагаа

“Хот девелопмент” ХК нь 2018 онд үйл ажиллагаагаа хэвийн явуулсан ба цаашид компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ салбарт үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөж байна. 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтаар Чойр өртөөнд Ложистик төв байгуулах ажлыг санхүүжүүлэх, бүтээн байгуулалтанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг босгохоор төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төсөл нь нийт 40 га газрыг хамран байрлах төмөр замд холбогдох боломжтой гэдгээрээ онцлог юм.

Компани одоогоор орон тоо болон бүтэц нэмэгдүүлээгүй бөгөөд тайлант хугацаанд Дөлгөөн хайрхан уул ХХК-иар Нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллаж байна.

Гол хувьцаа эзэмшигч Файрбөрд хөрөнгө оруулалтын сангаас авсан 200,000 ам долларын хөрвөх зээлийг хөрвүүлээгүй байгаа бөгөөд цаашид нэмэлт хувьцаа гаргах компанийн үнэн цэнийг өсгөх зорилгоор уг хөрвүүлэлтийг хийх төлөвлөгөөтэй байна.

III. Үнэт цаас гаргагчийн удирдлага

2018 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүтэц дараах байдалтай байна.

№	Хувьцаа эзэмшигч	Хувь
1	Hot Holdings S.A.R.L	74.53%
2	“БиДиСЕК ҮЦК” ХК	7.48%
3	5 хүртэлх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид	17.94%
	Нийт	100%

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“Хот девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 04 сарын 23-ны өдөр зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах.
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2018 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2018 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

2018 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг дараах байдлаар баталсан байна.

№	Зардлын төрөл	2017	2017	2018
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө
1	Бичиг хэрэг, шуудан холбооны зардал /интернет, веб/	80,000.00	-	80,000.00
2	Санхүүгийн төлбөр, аудитын зардал	250,000.00	250,000.00	250,000.00
3	Хөрөнгийн бирж, ҮЦТХТ-ийн төлбөр	460,900.00	460,900.00	660,900.00
4	Бусад /материалын зардал, зар сурталчилгаа/	400,000.00	279,800.00	320,000.00
5	Менежментийн төлбөр	-	-	-
6	Зээлийн хүүгийн зардал	49,790,600.00	48,701,784.67	47,885,400.00*
	Нийт	59,891,500.00	49,692,484.67	49,166,300.00

*USD ханшийг жилийн эцсийн дүнгээр авсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Жэймс Пассин, Б.Итгэл, Г.Заяа, Ж.Эрдэмбилэг, Д.Даянбилгүүн, Б.Мянганбаяр, хараат бус гишүүдээр М.Батсүрэн, Д.Нарангоо, Т.Тамир, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Ж.Эрдэмбилэг, Гүйцэтгэх захирлаар Б.Мянганбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Н.Батнайрамдал нарыг томилохоор шийдвэрлэсэн байна.

Мөн 2018 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг дараах байдлаар баталсан.

д/д	Зардлын төрөл	Нийт зардал
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах зардал	400,000
2	Бусад зардал	200,000
	Нийт	600,000

Төлөөлөн удирдах зөвлөл

№	Овог, нэр	Албан тушаал	Компанийн хувьцааг эзэмшдэг эсэх
1	Ж.Эрдэмбилэг	ТУЗ-ийн дарга	үгүй
2	Жэймс Пассин	ТУЗ-ийн ердийн гишүүн	үгүй
3	Б.Мянганбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал	үгүй
4	Б.Итгэл	ТУЗ-ийн ердийн гишүүн	үгүй
5	Г.Заяа	ТУЗ-ийн ердийн гишүүн	үгүй
6	Д. Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	үгүй
7	Т.Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн	үгүй
8	Д.Нарангоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	үгүй
9	М.Батсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	үгүй
10	Н.Батнайрамдал	ТУЗ-ийн нарийн бичиг	үгүй

Компанийн тухай хуулийн 75.8 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2018 оны 05 сарын 22-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

Цалин, урамшууллын хороо	1. Б.Мянганбаяр - /Хорооны дарга/ 2. Г.Заяа 3. Т.Тамир
Аудитын хороо	1. Г.Заяа - /Хорооны дарга/ 2. Д.Даянбилгүүн 3. Д.Нарангоо
Нэр дэвшүүлэх хороо	1. Б.Итгэл 2. Т.Тамир 3. Д.Нарангоо

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2018 онд гишүүдийн орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг онлайн болон гишүүд оролцсон хоёр хэлбэрээр хийсэн.

- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах, аудитын байгууллага сонгох, ТУЗ-ын дарга, ТУЗ-ын нарийн бичиг, Гүйцэтгэх захирал томилох, ТУЗ-ын аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо болон цалин урамшууллын хороо сонгох тухай компанийн удирдлага зохион байгуулалтын асуудал

IV. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварын тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, дүүргийн санхүүгийн хэлтэс, татварын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

Санхүүгийн үйл ажиллагаанд одоогоор гарсан томоохон гүйлгээ үл хөдлөх хөрөнгө худалдан авалт хийгдээгүй байна.

Тус компани нь одоогоор ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа тул 2017 оны байдлаар 50,880,890 төгрөгийн зардал гаргаж нийт 305,215,247.8 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Үзүүлэлт	2017	2018
Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
Борлуулалтын өртөг	-	-
Нийт ашиг (алдагдал)	-	-
Бусад орлого	-	273,020.60
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	1,016,224.64	1,383,327.53
Санхүүгийн зардал	48,701,784.67	49,497,562.42
Бусад зардал	-	-
Бусад олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	16,697,685.70	(254,580,076.37)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(33,020,323.61)	(305,187,945.72)
Орлогын татварын зардал	-	27,302.07
Татварын дараахь ашиг (алдагдал)	(33,020,323.61)	(305,215,247.79)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(33,020,323.61)	(305,215,247.79)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө оны эхэнд 14,217,116 төгрөг, жилийн эцэст 44,410,827 төгрөг байна.

Үзүүлэлт /төгрөгөөр/	2017	2018
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	14,217,116.99	44,410,827.64
Авлага	14,887,500.00	14,887,500.00
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	300,000.00	-
Нийт эргэлтийн хөрөнгө	29,404,616.99	59,298,327.64
Үндсэн хөрөнгө (цэвэр)	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	219,412,500.00	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө	219,412,500.00	-
Нийт хөрөнгийн дүн	248,817,116.99	59,298,327.64
Богино хугацаат өр төлбөр	705,997,798.23	821,694,256.67
Урт хугацаат өр төлбөр	-	-
Нийт өр төлбөр	705,997,798.23	821,694,256.67
Дүрмийн сан	3,988,500.00	3,988,500.00

Хуримтлагдсан ашиг/алдагдал/	(461,169,181.24)	(766,384,429.03)
Нийт эздийн өмч	(457,180,681.24)	(762,395,929.03)
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	248,817,116.99	59,298,327.64

Компани нь тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна.

V. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

Компанийн тухай хуулийн 46.1, 46.5 дугаар зүйлд заасны дагуу компанийн ТУЗ нь 2019 оны 02 сарын 11-ны өдрийн 19/08 тоот тогтоолоор 2018 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн.

Энэхүү ТУЗ-ийн шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46.2 дугаар зүйлд заасны дагуу компанийн ээлжит Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.